

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.27 № 80

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд нөхөн олговор олгож төсөвт хохирол учруулсан, цалингийн нөхөн олговрыг олгохдоо илүү олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын захирамжгүйгээр зарцуулсан, санхүүчдийн баярыг тохиолдуулан санхүүгийн албаны ажилчдад урамшуулал олгосон, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүй хөрөнгө акталсан, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан, хүчингүй болсон газар нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй, Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бус зарцуулсан, бараа материалыг анхан шатны баримтгүй, шууд зардалд бичсэн зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 17,704.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж,

0702000221

үнэ төлбөргүйгээр 362,208.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 22,184.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 67 арга хэмжээг бүрэн, 7 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээг хэрэгжээгүй нийт дүнгээр 96.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	322,927.97	411,585.06
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,181,135.16	1,403,040.76
	Нийт хөрөнгийн дүн	1,504,063.13	1,814,625.82
	Нийт өр төлбөрийн дүн	1,596.74	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,502,466.38	1,814,625.82
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,504,063.13	1,814,625.82
	Үйл ажиллагааны орлогын дүн	974,625.19	1,172,653.85
	Үйл ажиллагааны зардлын дүн	585,039.54	853,305.22
	Үйл ажиллагааны үр дүн	389,585.65	319,348.63
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	389,196.46	319,029.60
	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	1,502,466.38	1,814,625.82
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,760,649.72	-
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(258,183.33)
	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
	Тайлант оны үр дүн	-	312,159.43
	Эцсийн үлдэгдэл	1,502,466.38	1,814,625.82
	Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	496,935.86	757,112.67
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	485,379.86	739,407.93
	Үйл ажиллагааны ЦМГ	11,544.46	17,687.05
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(11,556.00)	(17,704.74)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	43,825.72	628,089.11
	Урсгал зардал	43,825.72	628,089.11
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	469,025.47	639,455.94
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	469,025.47	639,455.94

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 39,013.8 мянган төгрөгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал, 33,736.4 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Шүүхийн шийдвэрээр олгосон 33,736.4 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг авлагаар тусгаагүй, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 5,277.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"

Аудитаар нийт 60,371.9 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрч 1,666.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 58,705.8 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага.

5.1 Төлбөрийн акт

1. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд цалингийн нөхөн олговрыг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 1,434.1 мянган төгрөгийг суутгалгүйгээр илүү олгосон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 112/ШШ2022/0029 дугаартай шийдвэрийн 221-т Нэхэмжлэгч "Э.Нямбаатарыг сумын Засаг даргын албан тушаалд нь эгүүлэн тогтоох үндэслэлтэй байх тул түүний 2021 оны 10 дугаар сарын 04-с 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр буюу шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд ажилгүй байсан 235 хоногийн олговор 15.096,517 /арван таван сая ерэн зургаан мянга таван зуун арван долоон/ төгрөгийг Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.7-д "ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах, хуульд заасан хэмжээгээр шимтгэл төлөх, тайлагнах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснийг баталгаажуулах" гэж заасны дагуу уг олговроос эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих журмын дагуу тооцон суутгаж, үлдсэнийг нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэв" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгалгүйгээр илүү олгосон цалингийн нөхөн олговрын нийгмийн даатгалын шимтгэлийн мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын захирамжгүйгээр 232.0 мянган төгрөгийг байгууллагын машины засвар үйлчилгээний зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулалтын нийтлэг журмын 4.1-т Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Машины засварт зарцуулсан мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов

5.2 Албан шаардлага

1. Санхүүчдийн баярыг тохиолдуулан санхүүгийн албаны 4 хүнд 1,350.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-т "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид зааснаас бусад цалин хөлсийг албан хаагчдад олгохгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Өвс тэжээлийн агуулахын дээвэр засварласан 7,000.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүй, шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

3. Засаг даргын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагчдын дунд спортын наадам зохион байгуулж тэмцээний зардалд 3,500.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарсан Соёлын төвийн даргад хүндэтгэл үзүүлэхэд 230.0 төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 5.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгал, шагнал олгохгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Усан оргилуур барихтай холбоотой гарсан 1,598.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт жолоочийн тооцооны хуудасгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсанд үндэслэн шатахууны тооцоог бодож байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Цалингийн зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалийн шимтгэлд 1,109.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг

хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 33,746.4 мянган төгрөг олгож төсөвт хохирол учруулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлсэн.

7. Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 4,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 адууг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтгүй акталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална:1/ худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр акталсан хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

8. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6,166.8 мянган төгрөгийн 2 газрыг сумын Засаг даргын захирамжаар газрын хэмжээг өөрчилж хүчингүй болгосон боловч нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт хийгээгүй давхар бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхар бүртгэлтэй асуудлыг шийдвэрлэн, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв болгох албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Баян-уул сумын Засаг даргын Тамгын газар	Шүүхийн шийдвэрээр олгосон 33,736.4 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг авлагаар тусгаагүй	1	3,736.4	-	-	1	33,736.4	1	33,736.4	-	-	-	-
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 5,277.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	5,277.4	-	-	1	5,277.4	1	5,277.4	-	-	-	-
Дүн		2	39,013.8	0	-	2	39,013.8	2	39,013.8	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд цалингийн нөхөн олговрыг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 1,434.1 мянган төгрөгийг суутгалгүйгээр илүү олгосон.	1	1,434.1	1	1,434.1	-	-	-	-	-	-

Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын захирамжгүйгээр 232.0 мянган төгрөгийг байгууллагын машины засвар үйлчилгээний зардалд зарцуулсан.	1	232.0	1	232.0	-	-	-	-	-	-
	Санхүүчдийн баярыг тохиолдуулан санхүүгийн албаны 4 хүнд 1,350.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	1,356.0	-	-	-	1,356.0	-	-	-	-
	Өвс тэжээлийн агуулахын дээвэр засварласан 7,000.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүй, шууд зардалд бичсэн.	1	7,000.0	-	-	-	7,000.0	-	-	-	-
	Засаг даргын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагчдын дунд спортын наадам зохион байгуулж тэмцээний зардалд 3,500.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарсан Соёлын төвийн даргад хүндэтгэл үзүүлэхэд 230.0 төгрөг зарцуулсан байна.	1	3,730.0	-	-	-	3,730.0	-	-	-	-
	Усан оргилуур барихтай холбоотой гарсан 1,598.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт жолоочийн тооцооны хуудасгүй байна	1	1,598.0	-	-	-	1,598.0	-	-	-	-
	Цалингийн зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 1,109.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	1,109.0	-	-	-	1,109.0	-	-	-	-
	Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 33,746.4 мянган төгрөг олгож төсөвт хохирол учруулсан.	1	33,746.0	-	-	1	33,746.0	-	-	-	-

Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй 4,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 адууг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүй акталсан.	1	4,000.0	-	-	1	4,000.0	-	-	-	-
	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6,166.8 мянган төгрөгийн 2 газрыг сумын Засаг даргын захирамжаар газрын хэмжээг өөрчилж хүчингүй болгосон боловч нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт хийгээгүй давхар бүртгэлтэй байна.	1	6,166.8	-	-	1	6,166.8	-	-	-	-
Нийт		10	60,371.9	2	1,666.1	8	58,705.8	-	-	-	-